

# МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код: 65.020.40

<b>Бургасны модожсон, мөчрийн тайраадас Черенок зимний стеблевой ива.</b>	<b>MNS 3868:1986</b>
---	----------------------

БНМАУ-ын Үнэ, стандартын улсын хорооны 1986 оны 26 дугаар тогтоолын дагуу 1989 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хүртэл мөрдөнө.

**Энэ стандартын шаардлагыг заавал<sup>1</sup> дагаж мөрдөнө.**

Энэ стандарт нь бургаснаас модожсон мөчрийн тайраадсыг мод үржүүлгийн газарт бургасыг үндэслүүлэх зорилгоор түүнийг бэлтгэх буюу шалгаж хүлээн авах журмыг тогтооно.

## 1 ТЕХНИКИЙН ШААРДЛАГА

1.1. Бургасны модожсон мөчрийн тайраадсыг байгальд ургаж байгаа бургасны мөчир, хожуул буюу үндэсний ичмэл нахиа, тусгай зориулалтын эх ургамлаас ургасан нэг настай саваа мөчрөөс бэлтгэнэ.

1.2. Модожсон, мөчрийн тайраадас нь бүдүүн, нахианы байдлаараа I, II зэрэгт ангилагдана.

1.3. Мөчрийн тайраадасны урт нь хангай, хээрийн бүсэд 25-30 см байна.

1.4. Тайраадас нь бүр 8-аас доошгүй ширхэг нахиатай байна. Нахиа нь гэмтээгүй, шулуун, хортон шавьжинд нэрвэгдээгүй байна.

1.5. Бэлтгэсэн модожсон мөчрийн тайраадасны I,II зэргийн техникийн шаардлага нь хүснэгтэд заасан хэмжээнээс багагүй байна.

1.6. Бургасны модожсон мөчрийн I,II зэргийн тайраадсыг тусгай зориулалттай үйлдвэрийн эх ургамлын талбай байгуулах, гол мөрний дагуу ойжуулалтын ажил хийхэд хэрэглэнэ.

Нэр төрөл	I зэрэг	II зэрэг
Тайраадасны голч	/8-13/ мм	/5-8/мм
Нахианы байдал	Нэг ч нахиа гэмтээгүй байна.	Гэмтсэн нахиа 2ш-ээс ихгүй байна.

Тайлбар: Гэхдээ бэлтгэсэн тайраадасны хамгийн дээд үзүүрийн нахиа гэмтээгүй байна.

<sup>1</sup> Стандарчиллын үндэсний зөвлөлийн 2014 оны 38 дугаар тогтоолоор эрх зүйн хэм хэмжээг “сонгон хэрэглэх” болгон өөрчлөв.

## **2 МӨЧРИЙН ТАЙРААДАС БЭЛТГЭХ, ХАДГАЛАХ, ТЭЭВЭРЛЭХ ЖУРАМ**

2.1. Бургасны модожсон мөчрийг ургамлын өсөлт, хөгжилт зогссон тайван байдалд орсон үед /намраас хавар модны шүүс хөдлөх хүртэл/ бэлтгэнэ. Тайраадсыг бэлтгэхдээ бургасны саваа, мөчрийн доод, дунд хэсгээс бэлтгэнэ.

Тайраадасны нахиаг хугалж, гэмтээх, холтсыг шалбалахыг хориглоно.

2.2. Бэлтгэн авсан тайраадсыг стандартын дагуу зэрэглэж ялгасан байна.

2.3. Тайраадсыг савааны үзүүрийн болон доод талын нахиа тус бүрээс 3-4 мм зайтай тайрч бэлтгэнэ.

2.4. Бэлтгэж зэрэглэсэн мөчрийн тайраадсыг 50,100 ширхэгээр багцлан боож тусгай бэлтгэсэн зоорь, зориулалтын шуудуунд хадгалж цас, нойтон үртэс, чийгтэй элсээр хучна.

2.5. Тайраадасны чийгийг нь алдуулахгүйгээр үртэс, цасаар даруулсан брезнтээр хучиж тээвэрлэнэ.

2.6. Тайраадасны баглаа бүрт бургасны зүйлийн нэр, бэлтгэсэн газар, хугацаа, зэрэг тоо хэмжээг бичсэн хаягтай байна.

**ТӨГСӨВ**